

14

ГЛОБАЛЧЛАЛЫН АНХДУГААР ЭРИН: МОНГОЛЫН ИХ
ЭЗЭНТ ГҮРНИЙ ҮҮСЭЛ БУЮУ ЧИНГИС ХААНЫ
ЭДИЙН ЗАСГИЙН ОНОЛ*

Ronald Findlay, Mats Lundahl

1989 онд ЗХУ-д коммунизм нуран унаснаар Монголын нийгэм, эдийн засаг бүхэлдээ зогсонги байдалд орсон юм. Зөвлөлтийн үзүүлдэг гадаад тусламж гэнэт зогссон нь гадаад худалдааг уналтад оруулсан. Дөрвөн жил орчим хугацаанд ДНБ 20 гаруй хувиар унасан бөгөөд түүнээс хойш аажмаар өссөн ч 1989 оны түвшиндээ өнөө хүртэл эргэж хүрээгүй байна. Монгол Улс ихээхэн хурдацтай даяаршин буй ертөнцөд ямар ч бэлтгэлгүйгээр гэнэт орж ирсэн. Бараг 65 жилийн туршид оршин тогтносон коммунист систем нуран унахдаа Монголыг аливаа шууд нөлөөнөөс нь хамгаалах өчүүхэн ч хамгаалалтгүйгээр даяаршил руу огцом түлхснээр хохирол амсахад хүргэсэн.

Хэрэв бид энэхүү хандлагыг өмнөх түүхэн үеээр өргөжүүлбэл, Монгол Улс даяаршлын хохирогч болж буй нь түүхийн нэгэн гашуун егөөдөл гэлтэй. Мэдээллийн технологийн энэхүү эрин үед олон улсын худалдаа болон хүчин

* Draft versions of the paper was presented at the conference Asia, Europe, and Global Processes: Economic, Cultural, and Normative Dimensions, at the National University of Singapore, 14-16 March 2001, in two seminars at the National University of Mongolia, Ulaanbaatar, at the Faculty of Social Sciences and the School of Economic Studies, 14 March 2002, and at the First SSAPS Asia-Pacific Annual Conference in Gothenburg, 26-28 September 2002. We are grateful for the constructive comments received on all four occasions, and in addition to Stanley Engerman, for the same reason. The research has been funded by a Sarec grant, which is gratefully acknowledged. The paper contains some formalized economic theory, but hopefully this does not exclude the general reader from understanding the principles with the aid of simply the text.

зүйлийн шилжилт өргөжсөнөөр глобальчлал сүүлийн үеийн үзэгдэл биш гэдгийг амархан мартагдуулж байна (Findlay and Lundahl, 2000). Нөгөө талаас, ийм үзэл бодол нь цаагуураа глобальчлалыг үйл явц бус, нөхцөл байдал гэж үзэж байгаагаараа өнөөгийн түвшинд боломжгүй хандлага юм. Глобальчлалд хандах цорын ганц ухаалаг арга зам бол энэ нэр томъёог шууд утгаар нь буюу дэлхий хэрхэн даяаршин буйн түүх гэж үзэх явдал бөгөөд ингэснээр өнгөрсөн үеийг ч хамрах юм. Бид глобальчлал хэзээ, хаана эхэлсэн талаар тодорхой хариулт өгөх гэж оролдохгүй. Ингэх нь цагаа олоогүй, утгагүй оролдлого болно. Энэ сэдэвтэй холбоотой ажлууд хурдацтай хуримтлагдаж байгааг нягтлан үзэхэд ч энэ асуултыг хөндсөн зохиогчийн тоогоор хариулт байгааг харуулна.

Бидний тавьсан зорилгын хүрээнд дээрх асуултад тодорхой хариулт өгөх шаардлагагүй бөгөөд найман зууны тэртээд Монголчууд глобальчлалын хамгийн хүчирхэг давалгаан буюу глобальчлах хамгийн хүчтэй хүчин чармайлтыг гаргаж эхэлсэн гэдгийг тэмдэглэхэд л хангалттай. Тэд тухайн үйл явцын гол эзэд байсан бөгөөд глобальчлалыг тэр үеийн түвшинд хүргэсэн. Монголчуудын нүдээр харахад тэр үеийн глобальчлал өнөөгийнхтэй огтхон ч төсгүй гэдгийг хэлэх ч хэрэггүй биз. Энэ хоёрын хооронд үүнээс илүү ялгаа байх ч аргагүй. Эдгээрийг хэмжүүрийн хоёр эсрэг туйл гэж үзэх нь зүйтэй. Нэг туйлд нь бид арван гуравдугаар зууны үеийн үйл явцын идэвхтэй эзэд буюу үнэндээ түүнийг бүхэлд нь хянаж, тэр үеийн туршид бий болсон үр ашиг, өртөг зардлыг хуваарилах бараг бүрэн эрх мэдэл бүхий монголчуудыг харах болно. Харин нөгөө туйлд нь үйл явдал, тэдгээрийн үр дүнд ямарч байдлаар нөлөөлөх чадваргүй идэвхгүй хүлээн авагчид буюу дээр хэлсэнчлэн хохирогчдыг олж харна.

Энэхүү эсээ нь эдгээр глобальчлалын үеийн эхнийхийг нь тусгайлан авч үзнэ. Монголын эзлэн түрэмгийлэл нь дор хаяж хоёр зүйлээрээ онцлог юм. Мэдээж эхнийх нь түүний цар хүрээ билээ (Adshead, 1993:5). Монголын эзэнт гүрэн бол өнөөг хүртэл дэлхий дээр оршин байсан хамгийн том, тасралтгүй үргэлжилсэн гүрэн юм. Хубилай хааны өмнөд Хятад дах сүүлчийн эзлэн түрэмгийллийн дараа буюу өөрийн оргил үе болох 1279 онд энэ нь зүүн талдаа зүүн Сибир, Манжуур, Солонгос, Хятадын эргээс Аннам хүрч баруун талдаа Унгар, Польш, Беларус хүрч, өмнө хэсэгтээ Индочина, Бирма, Энэтхэгийн хойд хилээс эхлэн Персийн булангийн хязгаар, Ирак, Сирийн өмнөд хил, Туркийн өмнөд эрэг хүрч, умардад

Орос болон Сибирт ойролцоогоор хойд өргөрөгийн 60°-ын хооронд үргэлжилж байжээ. (Bat-Ochir Bold, 2001: xi).

Монголын эзлэн түрэмгийллийн хоёр дох онцлог нь магадлал муутай байдал юм. Арван хоёрдугаар зуунд Монголчууд 'хэл зүйн эсвэл угсаатны зүйн бие даасан бүлэг байгаагүй бөгөөд Монголын тал нутагт орших олон овог аймгууд дундах томоохон нэгэн аймаг л байсан' (Fletcher, 1986:13). Монголчууд өөрийн нэгдсэн аймгуудын эвсэлд өөрсдийн адил нэр өгсөн боловч аймаг ч тэр, эвсэл ч тэр дан ганц Монгол угсаатан болон хэлтнүүдээс бүрдэх боломжгүй байжээ. Монгол нутагт оршиж байсан өөр гурван гол эвсэл болох Татар, Найман, Хэрээдийн хувьд ч нөхцөл байдал үүнтэй адил байсан бөгөөд бүгд Турк угсаатан болон хэлтнүүдийг

агуулж байсан. Эндээс үзвэл, арван хоёрдугаар зуунд Монголын тал нутгийн хүн ам сая орчим хүнээс илүүгүй байх магадлалтай (Fletcher, 1986:22), бөгөөд магадгүй үүний хагас ч байсан байж болох юм (de Hartog, 1989:53). Энэ нь зуун солигдонгуут өнөөг хүртэл дэлхий дээр бий болж байгаагүй тийм том үргэлжилсэн эзэнт улс болтол нь газар нутагаа өргөжүүлж эхлэх хүмүүсийн хувьд итгэмээргүй дэндүү бага тоо юм.

Дараах хэсэгт бид Монголчууд хэрхэн нэгдсэн болон тэд хэрхэн тийм том эзэнт гүрнийг үүсгэн байгуулсныг Findlay and Wilson (1987), McGuire and Olson (1996), Olson (1965) and Findlay (1996) нарын хандлагын гол онцлогуудыг багтаасан загварараар тайлбарлана.

Монголчууд нэгдсэн нь: 'Стационар бандит' буюу засаг захиргаа бий болгосон нь

Гайхамшигт эзлэн түрэмгийллээ эхлэхийн өмнө Монголчууд нэгдэх ёстой байсан бөгөөд энэ нь өөрөө бараг биелэх боломжгүй зорилт байсан. Монголчуудын нэгдэх үйл явцын шинжилгээний логик санаа нь Joseph Fletcher (1986)-ийн ажигласнаар, уугуул тал нутаг нь Монголчуудын үйлдвэрлэлийн арга төдийгүй нийгмийнх нь хэв маягийг тодорхойлж байсан явдал юм. (cf. also Lattimore, 1951:53.83). Ер нь Төв Азийн тал нутгийн экологи суурин амьдралд ялангуяа газар тариаланд тохирохгүй байсан (Fairbank and Reischauer, 1979:154).

Owen Lattimore (1951:63)-ын шинжилгээгээр Шар мөрний нугалаанаас эхлэн тал хээр хүртэл үргэлжлэх газар нутагт Хятадын газар тариалангийн үр өгөөж буурдаг гэж дүгнэсэн байна. Ан агнуур болон мал аж ахуй нь тал нутгийн бүтээмжит хоёр аж ахуй байсан бөгөөд хоёулаа нүүдлийн амьдралын хэв маягийг шаарддаг. Тал газрын цаг уурын эрс тэс нөхцөл нь малчид төдийгүй хүн ам бүхлээрээ бэлчээр ус эрэн үе үе нүүдэллэхэд хүргэж байсан. 'Нэг бүлэг айлуудын мал, нэгэн аймгийн мал хөрөнгийн ихэнх нь, тэр ч байтугай нийт аймгуудын малын дийлэнх нь ч өвчин, өлсгөлөн зэргээс болж нэг шөнийн дотор алга болох эрсдэлтэй' тул нүүдэл бол зайлшгүй зүйл юм (Fletcher, 1986:13). Төв Азийн тал нутагт оршин тогтнох арга (Lipton, 1968) буюу амь аргацаах түвшнээс доош орох эрсдлийг хамгийн бага байлгах стратеги нь шалгарч, тогтсон чиглэлээр үе үе нүүдэллэх явдал юм. 'Нүүдэлчдийн' шилжих хөдөлгөөн нь ямар нэгэн зорилгогүй тэнүүчлэл биш бөгөөд ихэнхдээ улирлын чанартай, тухайлбал, задгай тал хээрийн зуны бэлчээрээс уулын хөндий зэрэг нөмөр газрын өвлийн бэлчээр лүү эсвэл эсрэг чиглэлээр хийдэг нүүдэл болно (Fairbank and Reischauer, 1979: 155). Ан агнууртай холбоотой нүүдэл нь ангийн гол амьтдын хөдөлгөөнөөр бүхэлдээ тодорхойлогдоно. Анчдын хийдэг зүйл нь ан, амьтдыг дагах юм.,

Иймд Төв Азийн тал нутгийн экологи нь хүн амыг шилжих, нүүх өндөр чадвартай болгосон байна. Түүнчлэн хомс ургамал нь төвлөрсөн хүн амыг хангах боломжгүйгээс хүн ам нь тархай суурьшсан байна (Lattimore, 1951:54, Fletcher, 1986:13-14). Том хэмжээний байгуулал нь суурин хүн амыг бодвол нүүдэлчин хүн амд ихээхэн бэрхшээлтэй асуудлуудыг бий болгодог. Үүнийг шинжлэхдээ, ямарч

хууль журамгүй Хоббес маягийн улсыг эхлээд авч үзье (Hobbes, 1985:Ch.13). Тэнд хүний амийг хамгаалах, нийтээр хүлээн зөвшөөрсөн ямар нэгэн хууль дүрэм байхгүй бөгөөд өмчийн эрх ч байхгүй. Хүмүүс бие биенээ хохирооход оногдуулах шийтгэл гэж байхгүй. 'Ийм нийгэмд амьдрал энгийн, хувиа хичээсэн, найдваргүй (Chambers, 1999:5) бөгөөд магадгүй 'ёс журамгүй, хэрцгий, богинохон' байна (Hobbes, 1985:186).

Тэгэхээр, талын амьдарлыг зохицуулж, хязгаарладаг хэлцэлд орсноос бий болох хожоо байх нь илэрхий байна. Чингис хааныг гарч ирэхээс өмнө Монгол хүмүүс 'өөр хоорондоо нэгдэх, хүний амь нас болон өмчийн аюулгүй байдлыг хангадаг нөхцөл байдлыг хүсэж байсан' гэж Paul Ratchnevsky (1991:14) үздэг. Хэд хэдэн аймгууд өөр хоорондоо дайтаж эсвэл өс хонзонтой байсан (Ratchnevsky, 1991:12) бөгөөд хууль жураг тогтоосноор хамрагдаж буй бүх талуудад харилцан үр ашигтай байсан. Олон аймгуудыг удирдах хүчирхэг удирдагч байхгүй байна гэж үзье. Тэгвэл дурын хэн нэгэн дээрэмчний хувьд зам нээлттэй байна. Тухайлбал, аймгууд, аймгийн бүлгүүд үе үе дээрэмчдийн халдлагад өртөнө гэдгээ тооцоолох ба дээрэмчид дараагийн дээрэм хийх таатай мөч хэзээ ирэхийг мэдэхгүй тул тухайн дээрмийн үед өөрсдийн чадах бүхнээ тононо.

Дээрэм тонуул байнга давтагдан гардаг болвол санамсаргүй 'дээрэм тонуулд өртөгсөд тэдний оронд 'стационар бандит' буюу "тогтсон" дээрэмчин бий болгох нь зайлшгүй. (Findlay and Wilson, 1987, McGuire and Olson, 1996, Olson 2000:6-12). Бүлгээс "тогтсон" дээрэмчинд тогтмол татвар санал болгох бөгөөд урт хугацаанд энэ шийдвэр нь санамсаргүй дээрэмд өртөхөөс бага зардалтай байх болно. Үүнийг дараах загвараар судлая.

Нүүдэлчин аймгийн үйлдвэрлэлийн дээд хэмжээ нь Y бөгөөд бодит үйлдвэрлэл нь I байна гэж үзье. Үйлдвэрлэлийн дээд хэмжээ нь хөдөлмөр (L), газар (T) болон хууль журам буюу засаг захиргааны хүнд суртлаас бий болдог нийгмийн бараа (G)-аас хамаарна. Үйлдвэрлэлийн дээд хэмжээ нь шугаман, нэгэн төрлийн функц байх ба дээрх гурван хүчин зүйлийн хувьд үр өгөөж нь буурдаг бөгөөд уламжлалууд нь эерэг байна. Хүнд суртал нь хувийн үйлдвэрлэлд хүчин зүйл болж хэрэглэгдэхээс өөр хэрэглээгүй бөгөөд төлбөрийг татварын мөнгөөр хийх ёстой. Иймд, татвар нь үйлдвэрлэх сонирхолд нөлөөлөх эрсдэл байнга байх бөгөөд тэгснээр бодит үйлдвэрлэл I нь Y -аас бага болно. I нь пропорциональ татварын түвшин t -ээс сөрөг хамаарна:

$$(1) \quad I \equiv r(t)Y(L, T, G), \quad r' < 0, \quad r(0) = 1$$

Ажиллах хүчин (N)-ийг өгөгдсөн гэж үзэх ба энэ нь үйлдвэрлэл болон хүнд суртлын тогтолцоонд ажиллагсдаас бүрдэнэ:

$$(2) \quad L + G = N$$

“Тогтсон” дээрэмчин өөрийн цэвэр татварын орлогыг хамгийн их байлгахыг эрмэлзэнэ:

$$(3) \quad R = tr(t)Y(L, T, G) - (1 - t)wG$$

энд

$$(4) \quad w = r(t)Y^L$$

Тухайлбал, хүнд сурталтнуудад төлөөд үлдсэн бүх татварын орлогыг “тогтсон” дээрэмчин авна. Хүнд сурталтнуудын авах нийт цалингийн хэмжээ нь үйлдвэрлэлд шууд оролцдог ажилчдын ахиу бүтээгдэхүүнтэй тэнцүү байна. Нэгэнт татвар нь шууд пропорциональ тул хүнд сурталтнууд ч өөрийн орлогоос бусдын нэгэн адил t хувиар татвар төлнө, тухайлбал удирдагчийн төлөх цалин нь $(1 - t)w$ байна.

Цэвэр татварын орлогоо хамгийн их байлгах үүднээс “тогтсон” дээрэмчин нь татварын түвшин ба хүнд сурталтын оновчтой хэмжээг олно, тухайлбал тэр (3)-ыг (2) нөхцөлтэйгөөр максимумчилна. Татварын орлого нь зааглалтаараа хязгаарлагдахгүй ба цэвэр орлогоос татварын түвшингээр уламжлал авж нэгдүгээр эрэмбийн нөхцлийг олно:

$$(5) \quad rY + rY^L G - (1 - t^*)r^*Y^L G = -t^*r^*Y$$

Татварын түвшинг өндөр болгосноор бий болох татварын нийт орлогын ахиу үр ашиг ба цалингийн (татварын дараах цалингийн бууралттай холбоотой) ахиу хэмнэлтийн нийлбэр нь татварын сөрөг нөлөөнөөс бий болох татварын нийт орлогын ахиу бууралттай тэнцүү байх ёстой. Иймд “тогтсон” дээрэмчин татварын түвшингийн өсөлтөөс бий болох татварын орлогын өсөлт нь үйлдвэрлэл буурснаас бий болох татварын орлогын бууралттай тэнцүү байх түвшингээр татвар ноогдуулна. Татварын сөрөг нөлөөгөөр үйлдвэрлэлийн дээд хэмжээ Y -ийн $1 - r(t)$ хэсэг нь алдагдах ба энэ алдагдлын t^* хувийг дээрэмчин өөрөө үүрнэ. Иймд татварын сөрөг нөлөөнөөс бий болох алдагдлын дээрэмчинд оногдох хувь татварын түвшингийн өсөлтөөс бий болох орлоготой нь тэнцэх яг тэр зааг дээр татварын түвшинг тогтооно. Татварын цэвэр орлогоо хамгийн их болгосноор дээрэмчин нийт үйлдвэрлэлийн өртгийн t^* хувийг авна.

Бидэнд нийгмийн барааны оновчтой хэмжээ бас хэрэгтэй бөгөөд үүнийг татварын цэвэр орлогоос G ба L -ээр харгалзан уламжлал авч олж болох юм. Ингэснээр дараах үр дүнд хүрнэ:

$$(6) \quad t^*rY^L - (1 - t^*)rY^{LL}G = t^*rY^G - (1 - t^*)r(Y^{LG}G + Y^L)$$

Шууд үйлдвэрлэлд оролцдог хөдөлмөрийн татварын орлогод нь оруулж буй ахиу хувь нэмэр (шууд хөдөлмөрийн буурч буй үр өгөөж нь нийт цалингийн түвшинг

бууруулах учир цалингийн төлбөрөөс бий болох ахиу хожоог оролцуулна) хүнд сурталтнуудын (тэдний шууд тооны өсөлт болон хүнд сурталтнууд нэмэгдэхэд шууд хөдөлмөрийн ахиу бүтээгдэхүүн улмаар нийт цалингийн түвшингийн өсөлттэй холбоотой хүнд сурталтнуудын тооны өсөлтөөс бий болох ахиу зардлыг хасна) оруулж буй ахиу хувь нэмэртэй тэнцэх хүртэл дээрэмчин тайван, хууль журамтай нөхцлийг нэмж бий болгох ёстой. Товчилсон тэмдэглэгээгээр:

$$(7) \quad \text{NMRPL} = \text{NMRPG}$$

энд NMRPL-ээр шууд үйлдвэрлэлд оролцдог хөдөлмөрийн ахиу цэвэр татварын орлогын бүтээгдэхүүнийг, NMRPG-ээр хүнд сурталтнуудын (хууль дүрэм) ахиу цэвэр ахиу татварын орлогын бүтээгдэхүүнийг тус тус тэмдэглэж байна.

"Тогтсон" дээрэмчин татвар ноогдуулалтаа 100 хувийн түвшинд хүрэхээс өмнө зогсоох төдийгүй нийгмийн бараагаар тухайн орон нутгийг хангахыг эрмэлзэнэ. Учир нь дээрхийн аль аль нь түүний татварын орлогыг нэмэгдүүлнэ. Энэхүү том захиргаадагч хүчин нь бүтээмжтэй ч, шуналтай ч байх болно.

Тал нутаг дах хууль журам

Хэдий тийм боловч, "тогтсон" дээрэмчинг бий болгох тийм хэлцэл хийгдэх эсэх нь өөрөө асуудал юм. Хууль журам нь нэгэн төрлийн нийгмийн бараа бөгөөд нэгэнт тогтсон л бол тухайн орон нутгийн бүх иргэд үр шимийг нь хүртэж, хэн ч түүний зохицуулалтын гадна үлдэхгүй. Гэхдээ яг энэ шалтгаанаар орон нутгийг зохион байгуулж, шаардлагатай хэлцлийг сайн дураараа хийх хүсэлтэй хэн нэгнийг олох хэцүү байж болох юм. "Тогтсон" дээрэмчин бий болгох нь өөрөө нийгмийн барааг тойрсон асуудлуудын нэг болох үнэгүй зорчих буюу "туулайчлал"-ын агуулж байдаг. Хэрэв бид Mancur Olson (1965, 1982)-ний гаргаж тавьсан "хамтарсан үйл ажиллагаа"-ны логикийг ашиглавал энэ асуудал хялбар болно.

Тал нутгийн хууль журмыг G буюу хүнд сурталтнуудын тоогоор төлөөлүүлбэл, хүнд суртал бий болгоход шаардагдах цаг хугацаа, хүчин чармайлт болон мөнгөн зардал нь түүнээс хамааран өсдөг функц байна гэж үзэж болно:

$$(8) \quad C = C(G), \quad C' > 0, \quad C'' > 0$$

Хүчин чармайлт гаргахгүй бол хууль журам тогтохгүй. Үр ашгийн талаас нь авч үзвэл, бүлэг буюу орон нутгийн үр ашиг нь бүхэлдээ хууль журмаас хамаарсан функц байна гэж үзэж болно:

$$(9) \quad B_c = L_c G$$

энд жижиг c үсгээр тухайн орон нутгийг тэмдэглэх ба L_c нь орон нутгийн хэмжээ бөгөөд тухайлбал, үүнийг хүнд хэцүү орчинд хүн амынх нь амь зуулганд зайлшгүй шаардлагатай мал, амьтдын орон нутаг дах тоо хэмжээгээр төлөөлүүлж болно.

Хүнд суртал G нь нийтийн үр ашгийг харуулах бөгөөд хэн нэгэн нэмэгдснээр нөгөөгийнх нь хүртэх үр ашиг буурахгүй, орон нутгийн нэг ч хүнийг түүний гадна орхих боломжгүй гэж үзнэ. Хувь хүний хүртэх F_i үр ашиг нь нийтээрээ хүртэж буй үр ашигаас бага байна:

$$(10) \quad B_i = F_i L_c G$$


Энд $F_i < 1$ нь тогтмол байна.

Хууль журам сахиулах үйл ажиллагаа явагдах уу? Хэрэв явагдвал хэр зэрэг явагдах вэ?

Орон нутгийн хүртэх үр ашигаас түүний гаргах зардлыг хассан зөрүүг хамгийн их байлгадаг тийм хүнд суртлын түвшин G -г оновчтой хэмжээ гэж үзнэ:

$$(10) \quad B_i = F_i L_c G$$

Ахиу үр ашиг нь хууль журам болон малын тоо толгойноос хамаарах бөгөөд хууль журам тогтооход гаргаж буй хүчин чармайлтын ахиу зардалтай тэнцүү байна. Хувь хүмүүсийн оновчтой шийдийг дээрхийн адил аргаар олбол:
Зураг 1.



Дээрх үр дүнгүүдийг энгийн графикаар үзүүлж болно (Зураг 1). Орон нутаг даяараа хүртэх үр ашгийн муруй B_c өсдөг боловч өсөлт нь яваандаа буурна. Хууль журам тогтооход гаргах хүчин чармайлтын ахиу үр ашиг буурна. Харин зардлын муруй C нь ахиу зардлын өсөлттэй холбоотойгоор монотон өснө. Орон нутаг дах хүнд суртлын оновчтой хэмжээ G_c^* нь орон нутгийн ахиу зардал, ахиу үр ашиг хоёрын тэнцвэрээр тодорхойлогдоно (а, b цэгт хоёр муруйн налалт нь тэнцүү байна). $F_i < 1$ гэдгээс хувь хүний хүртэх үр ашгийн муруй нь орон нутгийн муруйгаас доогуур байна. Зурагт үзүүлсэнчлэн, хувь хүний хувьд оновчтой хүнд суртлын түвшин нь

орон нутгийн хувьд оновчтой түвшингээс бага байна. Хувь хүний хүртэх ахиу үр ашгийн муруй нь ахиу зардлын муруйтай огтлолцох цэг нь G-ийн харьцангуй бага утганд харгалзаж байна (b, c цэгүүд).

Энэ нь Olson-ний нийтийн бараа дэд-оптимал (sub-optimal) хэмжээгээр үйлдвэрлэгдэнэ хэмээх алдарт дүгнэлт юм. Хүмүүс нь өөр хоорондоо адилгүй бөгөөд нийгмийн барааг орон нутаг нийтээрээ сонирхох түвшингээс бага сонирхож буй үед хэн нэгэн үүнийг зохион байгуулах ажлыг хийнэ гэж батлах нь ихээхэн төвөгтэй асуудал юм. Орон нутгийн оршин суугчдын тоо их байх тусам F_1 -ийн утга бага болох бөгөөд дэд-оптимум олдоход бүр л хэцүү болно (L_c тогтмол гэж үзнэ).

Дээрх бэрхшээлийн зэрэгцээ, бид талд энх тайван нөхцөл бий болгох хүчин чармайлт ер нь хийгдэх үү, үгүй юу гэдгийг бодолцох ёстой. Төв Азийн тал нутгийн бэлчээрийн эдийн засаг нь яг үүний эсрэг үйл ажиллагааг л харуулдаг: овог, аймгуудын хоорондын дайн, бэлчээр, мал ахуй тойрсон маргаан (Jackson and Morgan, 1990:8). Хэрэв зардлын муруй үр ашгийн муруйгаас бүхэлдээ дээгүүр оршиж байвал энх тайван байдал бий болгох оролдлого хэзээ ч хийгдэхгүй. Зураг 1.-ийн зардлын муруй нь хүн амын тоо төгсгөлөг байна гэсэн нөхцөлд үндэслэсэн. Хэрэв хүн амын тоо өсвөл, зардлын муруй ба босоо тэнхлэгийн огтлолцол нь дээш шилжих ба үүний хамт муруй бүхэлдээ шилжинэ. Хууль журам бий болгох талаар зөвшилцөх ёстой n тооны хүмүүс орон нутагт байна гэж үзье. Энэ бүх хүмүүс өөрөөсөө гадна n-1 хүнтэй зөвшилцөх ёстой. Жишээлбэл, хоёр талт хэлэлцээрийн тоо

$$(13) \quad K = \sum_{m=1}^{n-1} (n-m)$$

байна. Хэрэв хүн амын тоо n+1 болж өсвөл, хэлэлцээрийн тоо n-ээр өснө. Зардлын муруйн огтлолцол дээш шилжинэ. Иймд ямар нэгэн онцгой үйл явдал тохиолдохгүй л бол хүн болгон сонирхсноор аяндаа зохион байгуулагдах үйл явдал огт байхгүй ч байж болох юм.

Үүнээс үзвэл, зохион байгуулалтын тусгай механизм байхгүй нөхцөлд орон нутгийн хэмжээ нь үр ашиг, зардал хоёуланд нь нөлөөлөх замаар энх тайван бий болгох үйл ажиллагаанд саад болж байна. Чингис хаанаас өмнө Монголчуудын дунд засаг захиргаа, зохион байгуулалтад нөлөөлөх албан ёсны үйлчилгээ байгаагүй. Энэ нөхцөлд жижиг хэмжээний харилцан уялдаатай орон нутаг л зохион байгуулалтанд орох боломжтой.

Ахлагчийг сонгох үйл ажиллагаа

Монголчуудын овог, аймгийн удирдагчаа сонгох зохион байгуулалтыг нь харвал бидний дээр хийсэн дүгнэлт улам бүр батлагдах болно.

Joseph Fletcher (1979-1980:239, 1986:17)-ийн нэрлэснээр "танистр"-ийн ("tanistry") зарчим гэдэг нь тухайн овог, аймгийн ахлагчийн гэр бүлийн хамгийн сайн, чадварлаг гишүүн аймгийг удирдах ёстой гэж үздэг. Гэхдээ харилцан зөрчилтэй хоёр зарчим бас үйлчилж байсан. Үүнд, овгийн удирдлага удам дамжих буюу эцгээс хүүд шилжих, хоёрт, хөндлөн буюу ахаас нь дүүд шилжинэ. Энэ нөхцөлд, ахлагчаар хэнийг сонгох нь аймгийн тэргүүлэх гишүүдийн идэвхтэй сонголт, харилцан тохиролцооноос хамаарна. Ихэнхдээ, овог, аймгийн тэргүүлэх гишүүд ахлагчийг нэг их маргаангүйгээр амжилттай сонгож чаддаг байсан. Гэхдээ том бүлэг бүрдүүлэх гэж байгаа бол эсрэг тэсрэг маргаан байнга гардаг.

Монголын экологийн нөхцөл байдлаас үзвэл дээрхээс дээгүүр түвшний овог, аймгийн зохион байгуулалт байх шаардлагагүй юм. Чингис хаанаас өмнө Монголын нийгэм зөрчилдөөнтэй, тархай бутархай байсан. Ийм нийгэмд эрх мэдэл амархан олдож, амархан алдагддаг. Талын нүүдэлчдийн хувьд үүнийг шийддэг уламжлалт арга зам нь аймгууд илүү хүчтэй аймагт нэгдэх явдал юм. Зарим нь эзлэгдэн нэгддэг бол зарим нь хүчирхэг аймгийн хамгаалалтанд орохын тулд сайн дураараа нэгддэг.

Тэмүүжиний залуу насны амьдралын түүх нь зохион байгуулалттай холбоотой бэрхшээлээр дүүрэн байдаг. Түүнийг төрөх (1162 эсвэл 1167 он) үед (Grousset, 1966:36, Ratchnevsky, 1991:18-19) монголд нэгсэн эрх мэдэл байгаагүй. Түүний аав Есүхэйгийн эрх мэдэл нь хан цол хүртэхэд ч хүрэхгүй байсан (Morgan, 1986:57). Иймд залуу Тэмүүжин Монголчууд хоорондын төдийгүй Монголын нэгдсэн аймгуудын хоорондын ширүүн өрсөлдөөн дунд байсан. Монголын хамгийн алдартай гэр бүлийн гишүүний хувьд түүний 10 орчим наснаас 1190-ээд онд хаанаар сонгогдох хүртэлх амьдарлын түүх нь дайсан, амьдарлын төлөөх тэмцэл, дайн тулаанаар дүүрэн байсан. Тэр үед цус урсгахгүйгээр зохион байгуулалтанд орох боломжгүй байсан юм.

Энхтайван, аюулгүй байдал нь дээрх зохион байгуулалтын хүнд бэрхшээлүүдийг даван туулах хүчтэй шалтгаан байж чадахгүй. Түр зуурын аймгуудын эвсэл л тэдгээрт хангалттай. Харин баялаг бий болгох нь шалтгаан болж чадна. Тал нутгийн үйлдвэрлэлийн боломж нь их хэмжээний баялаг хуримтлуулахад хангалтгүй байсан. Бусад нүүдэлчдээс Монголчууд өөрсдийнх нь үйлдвэрлэдэгтэй ижил төрлийн бүтээгдэхүүн л олзолно. Гэвч энэ нь хөрөнгө, баялаг эрж хайдаггүй байсан гэсэн үг биш. William Baumol (1990) бүтээмжтэй болон бүтээмжгүй үйлдвэрлэлийг ялгаад, үйлдвэрлэл эрхлэгчид ашигаа хамгийн их байлгахыг сонирхоно гэдэг нь тэд бүтээмжтэй үйл ажиллагаа л явуулна гэсэн үг биш гэж дүгнэсэн. Хэрэв ашиг ихтэй л байвал үйлдвэрлэгчид бүтээмжгүй үйл ажиллагаа ч явуулна. Тэгвэл дайн, тонуул нь иймэрхүү өндөр үр ашигтай бүтээмжгүй үйл ажиллагаа байж болох юм.

Нүүдэлчдийн хувьд худалдаа хийх нь эхний хувилбар боловч энэ нь дээрэм, тонуулыг бодвол үр ашиг муутай. Гэхдээ энэ нь хэсэг бүлгээрээ, тус тусдаа бус нэгдсэн зохион байгуулалтанд орж, илүү өргөн цар хүрээтэй ажиллахыг шаардана.

Энэ нь орон нутгийнхний хүртэх үр ашгийг асар их нэмэгдүүлэх тул зохион байгуулалтанд орох бүрэн үндэслэл болж өгнө. Зохион байгуулалт нь энхтайван тогтоогоод зогсохгүй, гадаад бүлгийнхнийг хохироох замаар баяжих боломж олгоно.

Хятад улс гол бай болж байлаа. /1986-15-16/

Флетчерийн бодлоор, газар тариалангийн нийгмийн баялгийг булааж авах явдал нь нэгдсэн аймгуудын төрийн гол зорилго болж байсан бөгөөд өнөөгийн хандлагаас харвал энэ нь ихээхэн үнэмшилтэй дүгнэлт юм.

Гэхдээ ашиг, хожоотой дээрэм, тонуул хүртэл том хэмжээний зохион байгуулалтад шаардагдах хангалттай шалтгаан болж чадахгүй. Үндсэн овог аймгууд жижиг бөгөөд харилцан уялдаа холбоо муутай байсан. (Fletcher, 1986-20.21)

Монголчуудын овог аймгуудын удирдагчийг сонгох зөрчилдөөнтэй зарчмаас болоод нэгдсэн аймгуудын удирдагч хэн болох нь хэзээд тодорхой бус байдаг. Эвсэл, холбоо бий болж байвч түүнийг үндэслэгчдийн хувьд үйл явцаас гарах үр дүн нь тодорхойгүй байдаг. Цаашилбал, үйл явц нь түүнийг үндэслэгчид бүрэн төвлөрсөн байна. Монголчууд, (Fletcher, 1986-20.21):

...олон аймгуудын нүүдэлчин ардыг хаанчлах эрх мэдэл бүхий, нэгдсэн аймгуудын эзэн хаан, цэргийн хүчний өөрийн үнэнч удирдлага бүхий их хаанаар удирдуулж байсан. Аугаа хааны удирдлага дор бүх эрх мэдэл нь түүний ажлын алба, түүний өмнөөс үйл ажиллагаа явуулдаг төрийн түшмэдүүдэд бус харин зөвхөн өөрт нь буюу хувь хүнд төвлөрч байсан. Түүнийг нас барахад бүх эрх мэдэл нь үгүй болж эзэнт улс нь задран унасан.

Бүх үнэнч албатууд нь шууд хувь хүнийх нь хувьд зүтгэдэг. Fletcher (1986:22)-ийн хэлсэнчлэн, Монголын хувьд хувь хүний түүхэнд гүйцэтгэх үүргийг дутуу үнэлэх нь том алдаа хийхэд хүргэнэ. Монголын тогтолцоо нь хувь хүнийг дэмжиж, хувь хүн өөрөө хөтөлбөрөө гаргаж, хэрэв амжилтанд хүрвэл өөрөө бүх шийдвэрийг гаргах ёстой байсан (Fletcher, 1979-80:241):

Их хаан ... газар тариалангийн эзэнт улсын хаадын адил нэгэнт оршсоор төрт ёсыг зүгээр нэг үргэлжлүүлэгч байгаагүй юм. Тэрээр өөрийн цэргийн үйл ажиллагааг нийгмээс ихээхэн ангид армийн албан хаагч нартаа үүрэг болгон өгч чаддаггүй байсан. Удирдагч гадаад байдал, оршин буйгаараа эзэн хаан байлаа. Харин өөрийн хүмүүсийн эв нэгдлийг хангах явдал түүнийг идэвхитэй, зарчимч, цэргийн удирдагч байхыг шаардаж байсан. Энэхүү хувь хүн өөрөө нийгмийн гол хүн нь, үнэндээ гол ажилтан нь байсан.

Улс төрийн бүтэц хувирамтгай, хэврэг бөгөөд ихэвчлэн бүрэн задран унадаг байсан. Тал нутгийн эзэнт улс нь эзэн хааныхаа бүтээл болохоос эзэн хааныг

бүтээдэггүй юм. Эзэн хааныг үхэхэд, түүнийг залгамжлагч нь өөрийн бүтэц, өөрийн үнэнч албатуудыг зөвхөн өөртөө тулгуурлан үүсгэн байгуулах ёстой.

Түүхэнд давтагдашгүй хүмүүсийн нэг

Тэмүүжиний удирдлага дор (хожим нь Чингис хаан болсон) Монголчууд нэгдсэн. Энэ нь энхтайван замаар явагдаагүй боловч иргэний дайнаар л хязгаарлагдаж байсан. Эрх мэдэлд хүрэхийн тулд талын нүүдэлчдийг нэгтгэх ёстой гэдгийг Тэмүүжин ойлгож байлаа. Зөвхөн үүнийг биелүүлсний дараа л суурин соёл иргэншлийг эзлэх боломжтой болно. Гэвч үүний зэрэгцээ, овог аймгуудыг нэгтгэхийн тулд тэрээр дээрэм тонуулд боломж олгох ёстой. Энэ хоёрыг салгах аргагүй юм. Монголын нийгэм нь малчид, анчдын төдийгүй мөлжигч, тонуулчдын нийгэм байсан. Тухайлбал, дээрэм, тонуулыг зөвшөөрөхгүйгээр урт удаан үргэлжлэх эвсэл, холбоо үүсгэх боломжгүй гэж Fletcher (1986:15) дүгнэсэн байдаг. Холбоонд элсэгчдийн зүгээс харвал үүнийг ойлгоход хялбар болно. "Тогтсон" дээрэмчнээр удирдуулах нь үе үе болдог нэг удаагийн тонуулд өртсөнөөс дээр байх болно. Өмнө үзүүлсэнчлэн, "тогтсон" дээрэмчин татвараа хязгаартай тогтоохыг эрмэлзэнэ. Өөрөөр хэлбэл, тэрээр алтан өндөг гаргадаг галуугаа алахгүй. Тэр ч байтугай, өөр бусдаас татвар авдаг бол байдал бүүр дээр байх болно. Жишээлбэл, "тогтсон" дээрэмчин бусдыг дээрэмдэхэд өөрийн орон нутгийнхныг ашиглаж болно. Амь насаа алдах эрсдлийг эс тооцвол, удирдагч болон орон нутгийнхны хувьд энэ хувилбар нь Парето ашигтай юм.

Чингис хаан "төмөр мэт сахилга баттай, үнэнч шударга байдлыг дэмждэг, агуу авъястай удирдагч бөгөөд энэ талаараа тухайн үеийн тал нутгийн бүх удирдагчдаас гоц байсан байж таарна" (Fletcher, 1986:34). Гэвч, тэрээр Монгол үндэстнийг хэдэн зарчмуудад тулгуурлан зохион байгуулсан. "Аймгийн тогтолцоог хүлээн зөвшөөрөх, эсэргүүцэл үзүүлэх зэргийн хооронд чадварлаг маневр хийж байсны үр дүнд Тэмүүжин аймгийн тогтолцоог устгах ч, өөр нэг шинийг үүсгэх ч чадалтай, төгс удирдагч болж чадсан (Lattimore, 1963a:62). Энэ нь нэг бодлын тийм ч хэцүү биш байж болох юм. Учир нь, David Morgan (1986:37)-ний тэмдэглэснээр, аймаг нь харьцангуй нээлттэй байгууллага бөгөөд түүний гишүүнчлэл нь цусан төрөл төдийгүй улс төрийн сонирхлоор ч тодорхойлогддог байжээ. Тиймээс Тэмүүжинг овог, аймгийн бүтцийг зохицуулж эхлэх үед түүнийг дагалдахаас өөр аргагүй урьдын туршлага байсан. Гэвч зохицуулалтын цар хүрээ нь түүний өмнөх үеийнхний оролдлогоос хол давсан гэдгийг үгүйсгэх аргагүй.

Шашнаар хүлээн зөвшөөрөгдөхийн тулд Тэмүүжин өөрийгөө Монголын шүтээн болох дээд Тэнгэрээс илгээгдсэн элч хэмээн зарласан. 1206 оны их хуралдайгаар түүнийг Монголын их хаанаар өргөмжилсөн. Тэв тэнгэр хэмээх бөө нь түүнийг Мөнх Тэнгэрээс сонгогдсон хэмээн тунхагласан (Grouzet, 1970:217). Хожим тэр бөө түүний эрх мэдлийн эсрэг боссоны улмаас Тэмүүжин түүнийг цаазалсан байна (Ratchnevsky, 1991:96-101). Монголчууд ерөнхийдөө шашин шүтлэгт маш практик хандлагатай бөгөөд Чингис хаан өөрийн зорилгоо хэрэгжүүлэхэд үүнийг ашигласан. Тэрээр шашин шүтэх эрх чөлөөг бүрэн хангасан бөгөөд үүний дэргэд

тэр үеийн Христийн шашинт Европ нэн бүдүүлэг санагдана (Brent, 1976:43). Ингэхдээ итгэл үнэмшлээр удирдаад зогсохгүй, эзэнт гүрний нутаг дэвсгэр дээрх Муслим, Буддизм, Христийн урсгалуудын хоорондын зөрчилдөөнийг зохицуулахад болон шүтлэг бишрэлээс аль хааны эрх ашигт илүүтэй нийцэхийг сонгоход түүнийг ашиглах боломжтой юм.

Чингис хаан том хэмжээний зохион байгуулалтанд ороход саад болж байсан зарим уламжлалт бүтцийг эвдэж, феодалын нийгмийг үүсгэн байгуулахад шаардлагатай шинэ бүтцүүдийг бий болгосон. Монголын нүүдэлчин нийгмийг захирч эхлэх тэр үед Монголд цусан төрлийн удам дамждаг ураг төрлийн тогтолцоо оршиж байсан бөгөөд нүүдэлч дайчдын удам дамжсан цусан өс хонзонг дэвэргэдэг сул талтай. Ромчуудын адил хятадууд зэрлэгүүдийг зэрлэгээр нь хянуулах бодлого буюу дээрх сул талыг ашиглан овог аймгуудын хооронд нь хагаралдуулж, өөр хооронд нь дайтуулж байлаа.

Иймд Тэмүүжин аймгийн зарим зохион байгуулалтыг устгах, өөрчлөх шаардлагатай тулгарсан. Тангараг өргөсөн анд болох замаар аймгуудыг нэгтгэх нь яг нэг удмаас үүсэлтэй ахан дүүс шиг байх боловч яг удирдлагыг хэн гартаа авах гэдэг дээр ирэхээрээ ихээхэн зөрчилтэй болдог. Иймд Тэмүүжин үүний оронд илүү феодалын шинжтэй “нөхөр”-т тулгуурласан зохион байгуулалтыг сонгосон. “Нөхөр” гэдэг нь тэр үед удирдагчийн “хүн” гэж өөрийгөө нэрлэх, түүний төлөө өөрийн аймаг, гарал үүслээсээ ч татгалзсан байж болох дайчин гэсэн утгатай. Тэмүүжинг Чингис хаан болох үед түүний нэгтгэсэн нөхөд нь захирагч, генералууд болсон бөгөөд тэр тэдэнд хязгааргүй итгэдэг байсан (Lattimore, 1963a:59).

Монголчуудыг өөрийнхөө гарцаагүй удирдлагад нэгтгэж байх үедээ Тэмүүжин уламжлалт “хоёр аймаг” болох Боржигид болон Тайчудыг устгах ёстой болсон. Боржигид аймагт өөрөө хамрагдаж байсан ба Тайчуд түүний аавыг нас барах үед эрх мэдлийг өөртөө булаан авах гэсэн оролдлого хийсэн. Тэр Тайчудыг бүрэн дарж устгасан.

Тэмүүжин тараан бутаргах, эзлэн түрэмгийлэх өөрийн гэсэн аргатай байсан. Тэр өөртөө эзэнт гүрэн байгуулах зорилготой бөгөөд эзэнт улсууд нь уламжлалт аймгийн бүтцээс хамааралгүй байсан юм (Lattimore, 1963a:59).

Чингис хаан өөрт нь зүтгэж буй хүмүүст туйлийн шударга үнэнч бөгөөд түүний нөхөрлөл төгс төгөлдөр байх ба харин үүрэг хариуцлагаа биелүүлээгүй хүмүүстэй төдий хатуу тооцоо хийдэг байсан. Гайхалтай нь түүний генералуудаас нэг нь ч түүнээс урваж байгаагүй.

Чингис хааны удирдлага дор хууль журам тогтсон. Гэмт хэрэг, овог аймгуудын хоорондын дайн тулаан багассан байна. Хөршөө тонох нь өнгөрсөн явдал болж, дээрэмчид байхгүй болсон. Бэлчээр нутгийг бүх овог аймгуудад хуваарилж өгснөөр нэг гол маргааны эх сурвалж алга болсон. Гол замуудын аюулгүй байдлыг цагдаагийн хүчин хариуцаж, хулгайлагдсан малыг хууль ёсны эзэнд нь буцааж

өгөн, малын хулгайчийг цаазаар авах хүртэл ялаар шийтгэж байжээ (Brent, 1976:45-46).

Зохион байгуулалтын үндсэн дүрмүүд Их засаг-т тусгагдсан (Vernadsky, 1938, Ratchnevsky, 1991:187-96) бөгөөд эзэнт улсын хуулийн заалтуудыг 1206 онд тунхагласан ба энэ түүнийг 1227 онд нас барах хүртэл цааш нь хөгжүүлсээр байсан. Энэ нь нүүдлийн нийгмийн үндсэн шинж болсон төвөөс зугтах хүчний бэрхшээлийг даван туулахад тусалж, түүний засаг захиргааны үндэс суурь нь болсон. Хуулийн заалтууд нь хүмүүсийг төдийгүй засаг захиргааг бас хамарч байжээ. Үүрэг, хариуцлагыг үүгээр зохицуулж байв. Шашин шүтэх эрх чөлөөг тодорхой зааж өгсөн.

Чингис хаан өөрийнх нь улс төрийн байгуулалд хэрэглэж болох санааг бусдаас суралцах, зээлэх тал дээр их анхаарал тавьдаг байсан бөгөөд гадаадынхныг өөрийн зөвлөх, захирагчаар байнга авч ажиллуулдаг байв (Lattimore, 1963a:64).

Аянчид, дайны гэмт хэрэгтнүүдээс тогтмол мэдээлэл авдаг бөгөөд тагнуулын сүлжээ нь гадаад орнуудаас мэдээллээр хангадаг байсан (Brent, 1976:46). Мэдээллээр хангах тал дээр Муслимчууд (Турк, Иран, Араб) онцгой үүрэг гүйцэтгэж байв.

Урьдын дайн, тулалааны хүрээнд хэд хэдэн улс төрийн холбоо байгуулсныхаа дараа буюу 1190-ээд оны үед Тэмүүжин Хаанаар сонгогдсон байсан. Хаанаар сонгогдсон байсан ч тэрээр бүх Монголыг удирдлагадаа оруулаагүй байсан. Зуун солигдсны дараах эхний жилүүдэд ч тэр хэвээрээ байсан (Ratchnevsky, 1991:82). Түүний тулд илүү их зүйл шаардлагатай байсан. Дээр хэлсэн бүгд дээр нэмээд өөрийгөө цэргийн авъяастай гэдгийг харуулах ёстой. Энэ зорилгоор Тэмүүжин Монголын армийг дахин зохион байгуулсан. 1203 онд Хэрээдийн холбооны тэргүүлэгчийг ялсны дараа түүний хүмүүс аравтын тогтолцоогоор хуваагдсан (Brent, 1976:31). пбү дахин зохион байгуулсан. 1203 онд түүний Хэрэйтийн удирдагч буулган авсаны дараа тэрээр цэргүүдээ аравтын системээр хуваасан.

Тэр цэргүүдээ мянгатын нэгжид хуваасан. Аравтуудад хуваах тогтолцоо нь талын нүүдэлчдийн дунд нийтлэг байсан (Morgan, 1986:49). Янз бүрийн отогийнхнийг хольж хуваарилсан бөгөөд энэ нь уламжлалт эрх мэдлийн бүтцийг саармагжуулах нэг арга юм. 95 өрлөгүүд буюу шигшмэл жанжингаар мянгатуудыг захируулж байсан бөгөөд энэ нь орчин үеийн генералын тогтолцоотой төстэй юм (Онон, 1993:xiv). Чингис хааны шилдэг хоёр генерал болох Зэв болон Субэдэй нар 25 нас хүрэхээсээ өмнө цэргийн тийм өндөр албан тушаалтай болсон ба ахлах тушаалын офицеруудыг удирддаг байсан. Чингис хаан жанжин болон түүний дор албан хаагчдыг хоорондоо үнэнч шударга, дуулгавартай ажиллахыг шаарддаг байсан. Армийн нэг нэгжээс нөгөө нэгж рүү шилжихийг хатуу хориглосон бөгөөд цаазаар авах ял оногдуулахаар заасан байдаг.

1206 онд Чингис хаан удирдагч болсон нь түүний арми 105000 цэрэгтний болж түүнийг нас барах жил 129000 болж өссөн. Үүнийг тэр үеийн Европын армитай харьцуулбал харьцангуй том тоо юм. Тэмүжин өөрийн эзэнт улсын харуул хамгаалалтын тогтолцоог бий болгосон бөгөөд шөнийн 80 хамгаалагч, өдрийн 70 хамгаалагчтай байсан. Дээрх хамгаалагчид нь жирийн албан хаагчдаас дээгүүр зэрэглэлтэй байна. Энэ хамгаалалтынхныг «хоёр» зарчмаар бүрдүүлдэг: нэг талаас мэргэжилтнүүд, Тэмүүжингийн үнэнч албатууд, нөгөө талаас барьцаалал буюу өндөр албаны генералуудын хөвгүүд байна. Эзэнт гүрний хамгаалагчдын тоо 1206 оны их хуралдайн дараа 10000 болсон бөгөөд энэхүү хааны шууд удирдлаган дор өдөр тутам байдаг, түүнтэй-шууд харьцдаг бүлгээс өөрийн итгэлтэй цэргийн удирдагчдыг сонгох сайхан эх үүсвэр болдог байжээ.

Армийн шинэ зохион байгуулалт нь сахилга бат, цэргийн тактикийг сайжруулах энгийн нэгэн арга төдий байгаагүй. Энэ нь шинэ удирдагчийн улс төрийн эрх мэдлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг болж байсан. Шинэ зохион байгуулалт нь аймгийн тогтолцоог орлоогүй боловч, цэргийн үйл ажиллагааны хүрээнд аймгийн тогтолцоог тойрч гарах боломж олгож байжээ. Тухайлбал, энэхүү зохион байгуулалт нь аливаа хэрэг зөрчлийг шууд, бүрэн хянах боломжтой болгосон. Шинэ хэрэгсэл ажиллагаанд орж, нийт Монголыг бүхэлд нь удирдахад Хаанд саад болж байсан аймаг бүлгүүдийг тулаанаар ялсан. Энэ үйл ажиллагаа 3 орчим жил шаардсан. 1206 оны бар жил, Монголын 3 том голын нэг болох Онон голын хөвөөн дээр их хуралдай хийж түүний засаглалыг баталсан байна. Түүнээс хойш түүнийг Чингис Хаан гэж нэрлэх болсон.

Монголын эзлэн түрэмгийлэл

Монголын эзэнт улс хэрхэн тийм хэмжээнд хүрснийг судлах нь зүйтэй. Үүнийг өмнө гаргаж тавьсан загвараа Findlay (1996)-гийн загварын гол онцлогуудтай нэгтгэх замаар шинжилнэ. Findlay (1996:42) загвартаа нийт хүн амыг “нэгэн жигд талбай”-н нэг цэгт төвлөрнө гэж үзсэн (энэ нь ч Монголын тал нутгийн хувьд нилээн сайн ойролцоолол болж чадна). Монголын эдийн засагт хоёр биш харин гурван төрлийн үйл ажиллагаа явуулах боломжтой гэж үзье. Шууд хөдөлмөрийн оролцоо бүхий мал аж ахуйн үйлдвэрлэл, хууль журам сахиулдаг хүнд суртлаас гадна, ажиллах хүчнийг дайнд ашиглах боломжтой. Иймд нийт ажиллах хүчин N нь хоёр биш харин гурван төрлийн үйл ажиллагаанд хуваарилагдана.

$$(14) \quad L+G+A=N$$

Үүнд: L ажилчид шууд үйлдвэрлэлд оролцоно, G нь хүнд суртлын тогтолцоонд, A нь Монголын эзэнт улсын армийг бүрдүүлнэ. Арми болон хүнд суртал нь хоёулаа татварын мөнгөөр санхүүжигдэнэ.

Газар нутгийн хэмжээ нь арми болон цэргийн технологи m-ээс хамаарна:

$$(15) \quad T=T(A, m)$$

Эзлэгдсэн газар нутаг нь зөвхөн газар нутгийг өргөжүүлээд зогсохгүй, хүн ам нь үйлдвэрлэл, армид ашиглагдах боломжтой.

$$(16) \quad N = N[T(A, m)]$$

Өгөгдсөн цэргийн технологийн түвшинд Монголын эзэнт улсын оновчтой хэмжээ нь удирдагчийн зүгээс түүний цэвэр татварын орлогыг хамгийн их байлгахуйцаар тодорхойлогдоно:

$$(17) \quad R = t^*r(t)Y(L, T, G) - (1 - t^*)r(t)Y^L(G + A)$$

Цэвэр татварын орлогыг хамгийн их байлгах L, G, A -г тодорхойлох ба эдгээр нь

$$(18) \quad L + G + A = N[T(A)]$$

нөхцлийг хангаж байх ёстой. Ингэснээр дараах нэгдүгээр эрэмбийн нөхцлүүдийг тодорхойлно.

$$(19) \quad NMRPL = NMRPG = NMRPA$$

Энд

$$(20) \quad NMRPL = t^*rY^L - (1 - t^*)rY^{LL}(G + A)$$


$$(21) \quad NMRPG = t^*rY^G - (1 - t^*)r[Y^{LG}(G + A) + Y^L]$$

$$(22) \quad NMRPA = [t^*rY^T + NMRPL(dN/dT)](dT/dA) - (1 - t^*)r[Y^{LA}(G + A) + Y^L]$$

Үйлдвэрлэлд оролцож буй, хууль журам тогтоож буй болон армид буй хөдөлмөрийн цэвэр татварын ахиу орлогын бүтээгдэхүүнүүд нь хоорондоо тэнцүү байх ёстой. Сүүлийнх нь гурван зүйлээс бүрдэнэ. Эзлэгдсэн улсууд нь үйлдвэрлэлд ашиглагдах боломжтой газар нутгийг өргөжүүлэх ба түүний нэмж бүтээх өртөг (сүүдэр үнээр үнэлэгдсэн) нь газрын цэвэр татварын ахиу орлогын бүтээгдэхүүнтэй тэнцүү байна. Тэд мөн нутаг дэвсгэрийн хүн амыг нэмэгдүүлэх ба энэ нэмэгдсэн ажиллах хүчний бий болгох өртөг (сүүдэр үнээр үнэлэгдсэн) нь шууд үйлдвэрлэлд ажиллагсдын цэвэр татварын ахиу орлогын бүтээгдэхүүнтэй тэнцүү байна. Эцэст нь армийн хэмжээ өссөнөөр цалин өснө.

Тал нутгийн эрс тэс цаг уурын улмаас үйлдвэрлэлд ажиллагсдын ахиу бүтээгдэхүүн нь хууль журмаар зохицуулагдсан ч байсан тийм өндөр байх боломжгүй. Тэгвэл хүмүүсийг армид ашиглах нь илүү бүмээмжтэй стратеги байж болох юм. Монголын эх газрын эх газрын уур амьсгал нь далайгаас алслагдсантай холбоотойгоор туйлийн эрс тэс байдаг. 10-аас 4 сарын хооронд температур тэгээс доогуур байдаг бөгөөд өнөө үед Улаанбаатарт 1, 2-дугаар сард байнга 30-аас доош градус байна. Говь, цөлд зун температур 40 градус хүртэл өсөх ба өвөл -30 градус хүртэл хүйтэрнэ.

Энэхүү загварт эзэнт улсын газар нутгийг өргөжүүлэхэд армийн оруулах хувь нэмэр нь армийн хэмжээнээс хамаарсан хотгор функц байна гэж үзнэ. Энэ нь неоклассик эдийн засгийн онолын ердийн нөхцлүүдийн нэг бөгөөд газар нутгийн ахиу нэмэгдлийг боломжтой гэж үзэж байна. Гэхдээ энэ функц нь эхлээд гүдгэр байж байгаад дараа нь хотгор болж ч болно. Үүнийг зураг 2-т үзүүлээ.



Зураг 2.

Гөлгөр муруй нь армийн хэмжээ өсөхөд ахиу зардал (армид алба хаагчдын үйлдвэрлэх байсан бүтээгдэхүүнээр тооцсон) өсч буйг харуулж байна. S-хэлбэртэй муруйгаар ажиллах хүчин, газрыг нэмэгдүүлснээр бий болох үйлдвэрлэлийн ахиу үр ашгийг харуулж байна. Энэ муруй нь эхлээд өсөөд G цэгийг өнгөрөнгүүт буурч эхлэнэ. Дээрх хоёр муруй нь 3 удаа огтлолцоно. E цэгийн зүүн талд үр ашиг нь зардлаас өндөр байх тул армийн хэмжээг өсгөхөд хөрөнгө зарцуулна. Харин баруун талд нь зардлын муруй үр ашгийн муруйгаас дээр байрлах тул армийг өргөжүүлэхгүй. E цэг нь тогтвортой төлвийг харуулж байна. Харин F цэгээс цааш армийг өргөжүүлэх нь ашигтай тул армийн хэмжээ түүнээс холдон баруун тийш явсаар шинэ тэнцвэр H хүрнэ. Иймд F тогтворгүй төлвийг харуулна. Хангалттай том арми зохион байгуулж чадахгүйн улмаас газар нутагаа бага хэмжээтэй өргөжүүлдэг байжээ. E нь глобаль максимумын цэг биш боловч ямар нэгэн онцгой үйл явдал болохгүй л бол түүнээс цааш явах боломжгүй юм. Энэ нь Монголын онцлог болох зохион байгуулалтын бэрхшээлийг харуулж байна. Мөн түүнчлэн Монголын түүхэнд тохиолдсон онцгой үйл явдал нь нэгэн хүнтэй холбоотой бөгөөд энэ нь Чингис хаан юм. Чингис хаанаас өмнө Монголчууд өөрсдийг хүмүүс гэдэг талаас нь тодорхой мэдэрдэггүй байсан. Чингис хаан бол Монголчуудыг нэгтгэгч, агуу зохион байгуулагч юм (Fairbank and Reischaur, 1979:163). Аймгуудыг хангалттай том хэмжээгээр зохион байгуулснаар түүнийг залгамжлагчид дэлхийн хамгийн том үргэлжилсэн эзэнт улсыг байгуулах (магадгүй H цэгт ойртож очих) хүртэл үргэлжлэх тийм агуу үйл явцад түлхэц үзүүлсэн.

Дайны машин

Өмнөх загварт т-ээр төлөөлүүлэн авсан, цэргийн технологийн талаар бид одоогоор юу ч яриагүй байгаа билээ. Гэвч Чингис хаан энэ салбарт ч мөн шинийг санаачлагч байсан гэдэг нь эргэлзээгүй. Шинэ техник нэвтрүүлэх, боловсронгуй болгох чадвар бүхий цэргийн ухааны генийнхээ хувьд Чингис хаан Агуу Александр, Ганнибал, Цезарь, Аттила болон Наполеоноос илүү байсан гэдгийг Owen Lattimore (1963:66) дэмжсэн байдаг.

Монголчуудын цэргийн тактикийн зарчим төгс орчин үеийн байсан. Тэдний тулалдааны ялалтын нууц нь цэргийн зэвсэг, уян хатан хөдөлгөөнт байдал, тэсвэр хатуужилд нь байсан. Тэр үеийн Монголчуудын гол зэвсэг нь эмээл дээрээсээ хэрэглэхэд ихээхэн тохиромжтой нум юм. Монголчуудын нум тэр үедээ хамгийн боловсронгуй нь байсан бөгөөд бүхий л төрлийн нөхцөл байдалд зориулагдсан байдаг.

Арми бүхэлдээ морин цэргээс бүрдэж байсан нь түүнийг туйлийн уян хатан хөдөлгөөнтэй болгож байсан. Монгол морь маш их тэсвэртэй байдаг. Монголын арми тулалдааны үед дайснуудаасаа дор хаяж хоёр дахин хурдан нүүдэллэх чадвартай байсан.

Эдгээрээс гадна Монголын арми хэдэн сараар сургуулилт хийдэг байсан бөгөөд олж авсан чадвар нь үүний дараа үргэлжилдэг практик туршлагаар хадгалагдаж ирдэг. Монголын армийн дохиоллын тогтолцоо маш сайн хөгжсөн байсан. Хар цагаан туг ашигладаг байсан. Кидан улсаас уламжлалтай өртөөгөөр харилцаа холбоогоо хангадаг байсан. Яаралтай мэдээг өдөрт 200 гаруй милийн хурдтайгаар дамжуулах боломжтой байжээ.

Дүгнэлт

Монголын агуу эзэнт гүрнийг бий болгоход нөлөөлсөн хүчин зүйлүүдийг нэгтгэн дүгнэе. Тал нутгийн үйлдвэрлэлийн нөхцөл нь их хэмжээний хөрөнгийн хуримтлалыг боломжгүй болгож байсан бөгөөд харин цэргийн хүчин зохион байгуулах нь газар болон хүмүүсийн аль альных нь хувьд ахиу бүтээгдэхүүн өндөртэй байсан. Эзлэн түрэмгийлэх нь илүү сайн стратеги болжээ. Чингис хаанаас өмнө, Монголчууд нэгдэж, монголын газар нутгийг өргөжүүлэх боломжтой тийм арми байгуулах үйл явцад зохион байгуулалтын асуудал саад болж байсан. Зөвхөн түүний улс төр, цэрэг дайны чадвар тал нутгийн зохион байгуулалтанд саад болж байсан бэрхшээл "үнэгүй зорчих-туулайчлах"-ийг даван туулах боломжийг олгосон. Эцэст нь, Монголчууд дайн тулааны салбарт шинийг санаачлагчид байсан юм. Арми нь бараг бүхэлдээ морин цэргээс бүрдэж байсан бөгөөд цэргийн зэвсэг, уян хатан хөдөлгөөнтэй нийлээд тэр үеийн өрсөлдөгчдийнх нь хийж чадах зүйлээс асар давуу талтай байсан. Дайн тулааны талаарх Монгол ойлголт нь туйлийн "орчин үеийн", бас ямар нэгэн хэмжээгээр "бүхэл" байсан. Тэдэнд ямар нэгэн нөөц дайчид гэх ойлголт байгаагүй. Нөгөө талаас, Монголчууд,

нь хийж чадах зүйлээс асар давуу талтай байсан. Дайн тулааны талаарх Монгол ойлголт нь туйлийн "орчин үеийн", бас ямар нэгэн хэмжээгээр "бүхэл" байсан. Тэдэнд ямар нэгэн нөөц дайчид гэх ойлголт байгаагүй. Нөгөө талаас, Монголчууд, иргэдийн дунд аль болох их айлган сүрдүүлэх үйл ажиллагааг дайн тулааны нэг хэсэг гэж үздэг байсан. Үүний сургамж нь ойлгомжтой юм. "[Чингис] Хаан дайснууддаа эсэргүүцэл үзүүлэх нь ямар ч найдваргүй бөгөөд зохион байгуулах оролдлого хийвэл хамгийн харгис шийтгэл амсана гэдгийг сургахыг хүссэн. Зөвхөн хөнгөн шуурхай, тойрон хүрээлэх замаар шан харамж хүртэх буюу шууд бууж өгснөөр л амьд үлдэх болно."

Цэргийн сэдвийг орхихын өмнө бид нэг зүйл дээр их болгоомжтой хандах ёстой. Ratchnevsky (1991:170)-ийн сануулсанчлан, малчид, анчдаас бүрдсэн жижиг, хоцрогдсон, ядуу улс тэр үеийн Азийн хамгийн өндөр хөгжилтэй, шавхагдашгүй хүний нөөцтэй улсуудыг хэрхэн эзлэн түрэмгийлж чадсан бэ? гэсэн асуултын хариуг дан ганц цэрэг дайны хүчин зүйлээс бус, үүнд нөлөөлсөн өөр хоёр хүчин зүйлээс бас хайх ёстой. Нэгдүгээрт, армийн зохион байгуулалт бөгөөд энэ тухай дээр дурьдсан. Хоёрдугаарт, Чингис хааны улс төр, дипломат харилцааны чадвар болно (Ratchnevsky, 1991:172): "...дайсныхаа сул талыг судалж, түүнийг нь ашиглах явдал нь тулалдааны үр дүнг урьдаас тодорхойлдог байсан. Чингис хаан дайсныхаа хүрээнд буй үндэстний, нийгмийн, шашин шүтлэгийн аливаа зөрчилдөөнийг өөрийн давуу тал болгон ашиглах агуу их чадвартай байжээ." Иймд, цэрэг дайн, зохион байгуулалт, улс төр болон дипломат харилцааны чадвар бүгд нэг хүнд, Чингис хаанд цогцолсон нь Монголчуудын эзлэн түрэмгийллийг амжилтанд хүргэх баталгаа болж байжээ.

Нэгэнт ялалт хийсэн бол түүний олз омгийг хуваарилах болно. Чингис хаан дайны олз омог, хөрөнгө баялгийн талаар өөрийн хүмүүст өгсөн амлалтаа биелүүлдэг байсан. Эзлэгдэгсдийн хувьд энэ нь татвар төлнө гэсэн үг (Morgan, 1986:102, cf. Kwanten, 1979:209).

Орчуулсан Б.Алтанцэцэг